ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 02 өдөр Дугаар А/01 Шивээговь сум

Албан хаагчдын хоол унааны
нэмэгдэл хөлсийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/10 дугаар тушаал "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 12.1.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын хоол унааны нэмэгдэл хөлсийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хоногт 5000 (таван мянга) төгрөг байхаар шинэчлэн баталсугай.

2.Албан хаагчдад хоол унааны нэмэгдэл хөлсийг сар бүр бодож олгохыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д зөвшөөрсүгэй.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн "Ажилтан, албан хаагчдын хоол унааны нэмэгдэл хөлсийг шинэчлэн батлах тухай" А/06 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ц.ЦЭРЭНДОРЖ

D:\2023 oni barimt\TDarga\tushaal

42223 026